

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 07ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-6

1. Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудал	4-6
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 02-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Оюун-Эрдэнэ;
Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Ц.Туваан, Н.Учрал, Б.Хэрлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Лодойсамбуу;
Тасалсан: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Э.Болормаа, Э.Одбаяр, О.Цогтгэрэл, Б.Чойжилсүрэн.

Нэг.Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны даргад нэр дэвшигч, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Н.Мягмар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, референт А.Амармэнд, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Сонгуулийн ерөнхий хорооны даргад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Н.Мягмарыг нэр дэвшүүлж байгаа саналаа танилцуулав.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярбаатар: Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Нэргүйн Мягмарыг томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар “Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 06 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр 09 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 09 цаг 48 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяр, Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннямын Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд, Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалаа, Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Улсын Их Хурлын гишүүн Доржзодын Энхтуяа, Баярмагнайн Баярбаатар гэсэн гишүүд ирсэн тул хурлыг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцууллаа. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудал танилцуулъя.

1. Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох асуудал

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? айхгүй юу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.3 дахь хэсэгт хорооны дарга нарийн бичгийн даргыг хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын дарга Бямбацогт дарга санал танилцуулна. Бямбацогт даргаыг микрофоныг өгье өө.

С.Бямбацогт: Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт хорооны дарга, нарийн бичгийн дарга, хорооны гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилно гэж заасныг үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Нэргүйн Мягмарыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргаар танилцуулахаар санал болгож байна аа.

Нэргүй овогтой Мягмар нь 1976 онд Булган аймгийн Дашинчилэн суманд төрсөн. 1998 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн хууль зүйн магистр, 2005 онд Америкийн их сургуулийн Вашингтоны хуулийн коллежийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 1999-2006 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд багш, 2007-2009 онд ХЗДХЯ-нд ахлах мэргэжилтэн, газрын дарга, 2009-2010 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, 2010-2012 онд Монголын хөлөг онгоцны бүртгэл компанид менежер, 2012-2014 онд ХЗДХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, 2014-2016 онд АНУ-ын Сан Франциско хотод суугаа Ерөнхий консулын газарт Консул, 2017-2018 онд Азийн хөгжлийн банкны төслийн менежер, 2018-2023 онд ЗГХЭГ Хууль эрх зүйн газрын дарга, 2023-2024 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга, 2024-2026 онд ХЗДХЯ-ны ТНБД, 2026 оноос ЗГХЭГ-ын газрын дэд даргаар ажиллаж байна аа.

Нэргүйн Мягмар нь төрийн албанд удирдах албан тушаал хашиж байсан. Мэргэжлийн өндөр боловсрол, мэргэшлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлагатай зэргийг харгалзан түүнийг Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилуулах саналыг оруулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Б.Баярбаатар: Бямбацогт даргад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.2 дахь хэсэгт заасны дагуу нууц санал хураалт явуулахаар байгаа. Байнгын хороон дээр муу нууц санал хураалтыг цахимаар явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Энхтуяа гишүүн, Найдлаа гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй найдлаа гишүүнийх орж ирдэггүй ээ.

Номтойбаяр гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй.

Санал хураалт.

Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Нэргүй овогтой Мягмарыг томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

Санал хураалтад 18 гишүүн оролцсоноос 15 дэмжиж, 83.3 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Нэргүйн Мягмарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулна аа.

Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ баярлалаа.

09.54 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА